



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/244

Улаанбаатар хот

Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын
тооллогын бэлтгэл ажлыг хангах,
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 260 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/991 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогыг зохион байгуулах дүүргийн тооллогын түр болон хорооны товчооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тооллогны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тооллогод шаардагдах 3,480,000 (гурван сая дөрвөн зуун наян мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Хүн ам, орон сууцны завсрын тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангах, тоолох үе шатанд хийгдэх ажлыг хорооны нутаг дэвсгэрт үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг хорооны түр товчоо (Н.Нямзав, Б.Батзориг) нарт, тооллогын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангаж, ажиллахыг дүүргийн түр товчоо (Х.Цогцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 26-ны өдрийн 10219 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН ТООЛЛОГЫН ТҮР
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:
Комиссын орлогч
дарга:


Засаг даргын орлогч

Засаг даргын Тамгын газрын дарга
Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн
сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт,
тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Татварын хэлтсийн дарга
хөдөлмөр халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
1-р хорооны засаг дарга
2-р хорооны засаг дарга

Нарийн бичиг:

Статистикийн ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 13 ны өдрийн 13 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ХОРООНЫ ТООЛЛОГЫН ТҮР
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН


Дарга:
Гишүүд:

Хороодын засаг дарга
Хорооны зохион байгуулагч
Нийгмийн ажилтан
Улсын бүртгэгч
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
мэргэжилтэн
Хорооны цагдаа
Олон нийтийн цагдаа
Хэсгийн ахлагч нар

Нарийн бичиг:

Хорооны зохион байгуулагч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ... сарын ... ны өдрийн ... дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ХҮН АМ ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН
ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Нэгжний үнэ	6	80000	480000
	дүн			480.000

Тооллогын бэлтгэл ажлыг угтаж хийх ажилтны урамшуулал

№	Хороо	Орон тоо	Нэг сарын урамшуулал	Ажиллах сар	Нийт
1	1-р хороо	3	500000	1	1500000
2	2-р хороо	3	500000	1	1500000
	дүн				3.000,000
	Нийт дүн				3.480,000

